

5459567 СБА
Ард Кредит БСБ ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны Аарын/Х-өдрийн
2022/3 тоот Тогтоолын хавсралт
АРД КРЕДИТ
БСБ ХК
1119281372
УЛААНЧЛАЛЫН ХОТ

ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үндэслэл

1.1.1. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн баталсан Монгол улсын Компанийн засаглалын кодекс (цаашид “КЗК” гэх)-д заасны дагуу Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.

1.2. Зорилго

1.2.1. Энэхүү Залгамж халааны бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь “Ард Кредит БСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн эрх бүхий болон түлхүүр албан тушаалтны залгамж халааг урьдчилан бэлтгэх, хөгжүүлэх, сургахад оршино.

1.2.2. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан гэдэгт Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд Эрх бүхий албан тушаалтнаар тусгагдаагүй боловч бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, компанийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн хэрэгжилтэд чухал ач нөлөө, оролцоотой, компанийг төлөөлж гэрээ хэлцэл байгуулах эрх бүхий албан тушаалтуудыг хамруулан ойлгоно.

1.2.3. Компани нь мэргэжлийн өндөр ур чадвартай, хариуцлагатай, мэргэшсэн боловсон хүчний нийлүүлэлтийг хангахын тулд ажилтнуудын карьер хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, түлхүүр ажлын байранд тохирох хүний нөөцийг бэлтгэхийг зорино.

1.2.4. Компанийн Залгамж халааны бодлогын ач холбогдлыг Компанийн бүх ажилтнуудад сурталчилан таниулахад удирдлагын багийн гишүүд чухал үүрэгтэй оролцно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

2.1. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (цаашид “Хороо” гэх) нь энэхүү бодлогын хэрэгжилтийг хангуулах хөтөлбөр, төлөвлөгөө, нэр дэвшигчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг баталж, залгамж бэлтгэх үйл явцад дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.

2.2. Хүний нөөц хариуцсан алба, нэгж нь эрх бүхий болон түлхүүр албан тушаалттай хамтран залгамж халааг бэлтгэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж Хороонд танилцуулна.

2.3. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан нь өөрийн залгамж халааг бэлтгэхийн тулд өөрийн ажлын байранд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, Компанийн стратеги төлөвлөгөө, Хүний нөөцийн бодлого болон Боловсон хүчний сургалт, хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг үнэлэх, тайлагна замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан нь өөрийн ажлын байранд гурав хүргэлх нэр дэвшигчийг бэлтгэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэг хариуцлага нь тухайн ажилтны жилийн KPI-д тусгагдсан байна.

**Ард Кредит ББСБ ХК-ийн
Төлөвлөн удирдах зөвлөлийн
2022 оны 1 сарын 1 бодрийн
2021/35/г тоот Төмөролын хавсралт**

1119281372
УЛААНБАТАР ХСТ

2.5. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан нь өөрийн залгамж халааг өгөхөөр бэлтгэж буй нэр дэвшигчидтэй сард нэгээс доошгүй удаа уулзаж, залгамж халаа бэлтгэх хөтөлбөр, сургалт, хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэн, сайжруулалт хийж, Хороо болон ТУЗ-д тайлагнаж ажиллана.

2.6. Хүний нөөц хариуцсан алба, нэгж нь урт хугацааны чөлөө авах, богино хугацаанд томилолтоор гадаад, дотоодод ажиллах, ээлжийн амралт авах, жирэмсний амралт авах гэх мэт таамаглаж болохуйц эрх бүхий болон түлхүүр ажлын байрны хэрэгцээг урьдчилан төлөвлөх бөгөөд залгамж бэлтгэх үйл явц нь батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу шат дараалалтайгаар хэрэгжинэ.

2.7. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан нь залгамж бэлтгэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг тухай бүр Хороо болон ТУЗ-ийн хурлаар тайлагнах үүргийг хүлээнэ.

2.8. Компани нь ажлаас гарах, нас барах гэх мэт гэнэтийн болон гэнэтийн бус нөхцөл байдлаас үүдэх эрх бүхий болон түлхүүр ажлын байрны сүл орон тоог нөхөх болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөөтэй байна.

2.10. Хороо нь уг Бодлоготой уялдан гарах Компанийн дотоод журам, зааврыг хэлэлцэж, зөвлөмж гаргана.

ГУРАВ. БУСАД

3.1. Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.